

ЮНЕСКО-ИЙН СУРАЛЦАГЧ ХОТУУДЫН ДЭЛХИЙН СҮЛЖЭЭ

ЮНЕСКО-ийн Насан туршийн суралцахуйн хүрээлэнгээс
боловсруулсан бичиг баримтуудын түүвэр

ГАРЫН АВЛАГА



ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс (НҮБ-ын байр, Нэгдсэн үндэстний гудамж 14, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс) болон Боловсролын яам (Засгийн газрын III байр, Бага тойруу 44, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот) хамтран 2025 онд эрхлэх гаргав.

© ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс

Агуулга

| | |
|---|-----------|
| Удиртгал | 04 |
| ЮНЕСКО-ийн Суралцагч хот гэж юуг хэлэх вэ? | 05 |
| Суралцагч хотуудын гол шинж чанарууд | 07 |
| Суралцагч хот хэрхэн байгуулах вэ? | 08 |
| Өргөдөл гаргах журам | 12 |
| Суралцагч хотын шалгуур үзүүлэлтүүд | 14 |
| ЮНЕСКО-ийн Суралцагч хотуудын дэлхийн сүлжээ товчоор | 15 |
| Хавсралт 1. Суралцагч хотын үндсэн шинж чанарууд ба үнэлгээний аргачлал. | 16 |
| Хавсралт 2. Суралцагч хотуудын үндсэн шинж чанар ба Тогтвортой хөгжлийн зорилгууд. | 26 |
| Эх сурвалж | 26 |

Удиртгал

ЮНЕСКО-ийн Суралцагч хотуудын дэлхийн сүлжээ (СХДС) нь урам зориг, ноу-хау, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлдэг бодлогод суурилсан олон улсын сүлжээ юм. Сүлжээний эрхэм зорилгод сүлжээний гишүүн хотуудын хооронд бодлогын яриа хэлэлцээ, нэг нэгнээсээ суралцах, туршлага хуримтлуулах, хамтран ажиллах, түншлэлийг дэмжих, харилцан чадавхыг бэхжүүлэх болон суралцагч хотуудыг шинээр байгуулах, ахиц дэвшлийг үнэлэх арга зүйг боловсруулах тус тус орно.

Энэхүү сүлжээ нь 2013 онд зохион байгуулагдсан Суралцагч хотын асуудлаарх олон улсын бага хурлаар баталсан "Суралцагч хотуудыг байгуулах тухай Бээжингийн тунхаглал" болон "Суралцагч хотуудын онцлог шинж чанар" гэсэн хоёр баримт бичигт үндэслэгдсэн. Сүлжээтэй холбоотой бусад баримт бичгүүдэд "Суралцагч хотууд ба тогтвортой хөгжлийн зорилгууд: Үйл ажиллагааны гарын авлага" болон "Суралцагч хот байгуулах удирдамж" зэрэг багтдаг.

ЮНЕСКО-ийн СХДС нь 2015 онд сүлжээндээ бүртгэж эхэлсэн бөгөөд өнөөгийн байдлаар гишүүдийн тоо 356 болон нэмэгджээ. ЮНЕСКО-ийн СХДС-ний гишүүд суралцагч хотуудыг байгуулах ажилд идэвхтэй оролцдог бөгөөд насан туршийн суралцахуй нь хотын ирээдүйд үнэтэй хувь нэмэр оруулдаг үздэг. Сүлжээний гишүүн болох хүсэлт гаргахдаа аливаа хот суралцагч хот болон хөгжих, сайн туршлагаас хуваалцах, түншлэлийг дэмжих, ирээдүйн бодлого, стратегийг бэхжүүлэх, бүх нийтийн насан туршийн суралцахуйг хэрэгжүүлэх үүрэг амлалтаа хүлээж байдаг билээ.

ЮНЕСКО-ийн Суралцагч хот гэж юуг хэлэх вэ?

ЮНЕСКО-ийн Суралцагч хотуудын сүлжээний гишүүн гэдэг нь хотын зөвлөл эсвэл хотын захирагч эсвэл бусад хэлбэрийн (ИТХ г.м) удирдлагатай засаг захиргааны нэгж байх бөгөөд, оршин суугаа улсынхаа засгийн газраас хот хэмээн хүлээн зөвшөөрдсөн байна. Суралцагч хот нь хот, нийслэл, тосгон / сум/, эсвэл суралцах нийгэмлэг байж болох юм.

Дэлхийн хотууд хэдий соёл, угсаатан зүй, өв уламжлал, нийгмийн бүтцээрээ ялгаатай ч суралцагч хотуудад олон нийтлэг шинж байдаг бөгөөд ихэвчлэн дараах шинж чанарыг агуулсан байдаг. Үүнд:

- Суурь боловсролоос дээд боловсрол хүртэл боловсролын хүртээмжтэй байдлыг хангасан
- Гэр бүл болон хамт олныг суралцахад уриалж, дэмжсэн
- Ажлын байрандаа суралцах нөхцөлөөр хангасан
- Орчин үеийн сургалтын технологийн хэрэглээг нэвтрүүлсэн
- Сургалтын чанар, агуулгыг үргэлж нэмэгдүүлж байдаг
- Насан туршдаа суралцах соёлыг төлөвшүүлэхэд хүчин чармайлт гаргадаг
- Хувь хүний хөгжил, нийгмийн эв нэгдэл, эдийн засаг, соёлын хөгжил цэцэглэлт, тогтвортой хөгжлийг бэхжүүлж байдаг зэрэг орно.

Суралцагч хот нь хүн бүрийг насан туршдаа суралцах, боловсрол эзэмших эрхээ эдлэх нөхцөлөөр хангаж, дэмжиж байдаг учраас суралцагч хот байгуулах нь урт хугацааны ач холбогдолтой бөгөөд тасралтгүй үргэлжлэх үйл явц юм. Суралцагч хот гэх статусыг авахад заавал биелүүлэх ёстой тогтсон шаардлага, давсан байх дээс шугам гэж байхгүй. Тиймээс тухайн хот ямар гэдгээс илүүтэйгээр юу хийж байгаагаар нь суралцагч хот болох тодорхой шинж чанарууд байдаг. Суралцагч хот байгуулах нь насан туршийн суралцахуйг хөгжүүлэх үйл ажиллагааны болон практикт суурилсан арга зүй, бодлогын хандлагыг шаардаж байдаг. Хэрэв тухайн хот суралцах хот болох улс төрийн хүсэл эрмэлзэл, түүнийгээ биелүүлэх үүрэг амлалт хүлээхэд бэлэн бол ахиц дэвшлээ хянах индикатор үзүүлэлтүүд тогтоох шаардлагатай. Энгийнээр хэлбэл, суралцагч хотын ахиц дэвшлийг хянах нь дараах гурван үндсэн шалтгааны улмаас зайлшгүй шаардлагатай.

Үүнд:

1. Онол болон улс төрийн яриа хэлэлцээрийг тодорхой стратеги, хандлага болгон бодитоор хэрэгжүүлэх,
2. Ахиц дэвшлийг хэмжих, үнэлэх
3. Хэрэгжүүлсэн стратегийн үр өгөөжийг үнэлэх зэрэг юм.

2012-2013 онуудад ЮНЕСКО-ийн Насан туршийн суралцахуйн хүрээлэн (UIL^[1])-ээс Суралцагч хотуудын үндсэн шинж чанар юу байх талаар хэлэлцэж, биелүүлсэн байвал зохилтой 42 ерөнхий, хэмжигдэхүйц шинж чанаруудыг нэрлэсэн байдаг. (Хавсралт 1-ээс дэлгэрүүлж харна уу) Эдгээр шинж чанаруудыг хангаснаар хотууд иргэдийн болон олон улсад насан туршийн суралцахуйг хөгжүүлэх, ахиц дэвшлээ үнэлэх, олон улсын харьцуулсан дүн шинжилгээ хийх, гишүүн хотуудтай туршлага солилцох, түншлэл тогтоох боломж бүрдэх юм.

Эдгээр үндсэн шинж чанаруудыг ЮНЕСКО-ийн Суралцагч хотуудын засаг дарга нар, нийслэлийн боловсролын газрын удирдлагууд, мөн суралцагч хотуудын асуудлаарх олон улсын бага хуралд оролцогч мэргэжилтн, судлаачид хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан тул эдгээр жагсаалт нь суралцагч хот байгуулахад туслах, жишиг болгох (checklist) баримт бичиг юм. Түүнчлэн, СХДС-ний гишүүн болоход ЮНЕСКО-ийн гишүүн орнуудын эрх бүхий байгууллага (тухайлбал ЮНЕСКО-ийн үндэсний комисс) нэр дэвшүүлдэг бөгөөд энэхүү жагсаалтад тулгуурлан хотуудыг сонгож, үнэлэж, нэр дэвшүүлдэг. Үүнээс гадна, аливаа улсын эрх баригчид суралцагч улс орон, бүс нутаг, олон нийт байгуулах, хөгжүүлэх санаачилгын хүрээнд тус жагсаалтыг лавлах баримт бичиг болгон ашиглаж болно.

Тэгвэл ЮНЕСКО-ийн СХДС-ний гишүүн болсоноор ямар давуу талтай вэ?

1. Суралцагч хот байгуулах, цаашид хөгжүүлэх дэмжлэг авах
 - a. Суралцагч хот байгуулах, хөгжүүлэх арга зүй, хэрэглүүр, стратегид суралцах (тухайлбал, сургалтын модуль, видео хичээл г.м.)
 - b. Хамгийн сүүлийн үеийн судалгаа, гишүүн орнуудын сайн туршлага, тайлангаас мэдээлэл олж авах
 - c. ЮНЕСКО-ийн СХДС-ний Зохицуулах багаас дэлхийн өнцөг булан бүрт байгаа суралцагч хотуудын хөгжлийн талаарх мэдээ мэдээлли йг тогтмол хүлээн авах
2. Идэвхтэй олон улсын сүлжээний нэг хэсэг болж, бусад гишүүдтэй хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх
 - a. Олон улсын хурал, бүс нутгийн уулзалтуудыг зохион байгуулахад дэмжлэг авах
 - b. Нийтлэг сонирхол бүхий бусад суралцагч хотуудтай харилцаа холбоо тогтоох, нийтлэг алсын хараа бүхий хөгжлийн хөтөлбөрүүдийг хамтран боловсруулах
 - c. Тогтвортой хөгжил болон насан туршийн суралцахуйн чиглэлийн мэргэжилтэн, шинжээч нартай харилцаа холбоо тогтоох
 - d. Сүлжээний гишүүдээс (хотууд) арга зүйн дэмжлэг авч байх

[1] UNESCO Institute of Lifelong Learning

3. Суралцагч хот байгуулах, хөгжүүлэхэд гаргасан хичээл зүтгэлийг үнэлүүлэх, олон улсад суртачлах
 - a. ЮНЕСКО-ийн СХДС-ний сувгуудаар дамжуулан туршлага, ахиц дэвшлээ түгээн дэлгэрүүлэх
 - b. Бусад улс орнуудад өөрийн хотын жишээн дээр суралцахад дэмжлэг үзүүлэх
 - c. ЮНЕСКО-ийн "Суралцагч хот"-ын шагналд нэр дэвших, шагнал авах зэрэг давуу талуудыг эдлэх юм.

Суралцагч хотуудын гол шинж чанарууд

ЮНЕСКО-оос баталсан суралцагч хотуудын шинж чанаруудыг Зураг 1-т үзүүлсэнчлэн ЮНЕСКО-ийн лого дээр тайлбарлая.



Зураг 1. Суралцагч хотын үндсэн шинж чанарууд

Багана – суралцагч хот байгуулахад анхаарах 6 суурь зарчмууд. Үүнд:

1. Боловсролын тэгш хамруулалт
2. Гэр бүл, олон нийтээс суралцахуй
3. Ажлын байран дахь суралцахуй
4. Орчин үеийн сургалтын технологийг өргөнөөр ашиглах
5. Боловсролын чанарыг сайжруулах
6. Насан туршдаа суралцах соёлыг нийгэмд төлөвшүүлэх.

Шат – суралцагч хот байгуулах суурь нөхцөлүүдийг заасан байна. Үүнд:

1. Улс төрийн амлалт, хүсэл зориг, тууштай байдал
2. Оролцогч талуудын үүрэг, оролцоо ба засаглал
3. Нөөцийн ашиглалт ба бүрдүүлэлт гэх гурван суурь нөхцлүүдээс бүрдэнэ

ЮНЕСКО-ийн Насан туршийн суралцахуйн хүрээлэнгээс суралцагч хотуудын нийт 42 шинж чанаруудыг (Хүснэгт 1-ээс харна уу) тодорхойлсон байдаг ба тэдгээрийн ихэнх нь хэмжигдэхүйц бөгөөд холбогдох статистик мэдээллийг хотын захиргаа, газар, нэгж гаргах боломжтой индикаторууд байдаг. Индикаторуудыг заримыг нь Gallop зэрэг бие даасан мэргэжлийн байгууллагуудын хийсэн судалгааны үр дүнгээр хэмжиж болох бол заримыг нь хотын захиргааны тайлан, мэдээлэлд шинжилгээ дүгнэлт хийн бодож болно. ЮНЕСКО-оос тодорхойлсон суралцагч хотын шинж чанарууд нь нийтлэг стандарт биш билээ. Хот бүр өөр өөрийн өвөрмөц соёл, нийгэм, эдийн засаг, түүх, өв уламжлалтай тул ахиц дэвшлээ өөрийн онцлогт тохируулан хэмжих боломжтой тул үнэлгээний жишиг, удирдамж болгон ашигдах нь зүйтэй юм.

Суралцагч хот хэрхэн байгуулах вэ?

ЮНЕСКО-ийн таван бүс нутгийн олон улсын шинжээчдийн зөвлөгөөний үндсэн дээр боловсруулагдсан суралцагч хот байгуулах удирдамж, заавар боловсруулагдсан бөгөөд энэ нь "Хотод оршин суугдчын нөөц бололцоог нээн илрүүлэх нь: 12 суралцагч хотын кейс судалгаа[2]"-ны үр дүнд тулгуурласан болно. Эдгээр заавар, зөвлөгөө нь эрч хүчтэй, тогтвортой суралцагч хотуудыг байгуулах ерөнхий чиглэл, арга зүй, суралцагч хот байгуулах аливаа үе шат тухай бүрт хэрэглэж болохуйц хэрэгжүүлэх боломжтой зөвлөмжүүдийг агуулдаг.

Удирдамж нь хот бүр өөрийн өвөрмөц нөхцөл байдалд тохируулан ашиглах боломжтой дараах зургаан үндсэн чиглэлд хуваагдсан болно. Үүнд:

1. Суралцагч хот байгуулах төлөвлөгөө боловсруулах;
2. Оролцогч талуудыг хамруулсан зохион байгуулалтын бүтцийг бий болгох;
3. Баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, заншил болгох;
4. Бүх иргэдийн хүртээмжтэй боловсрол, суралцахуйг хангах;
5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний механизмыг бий болгох;
6. Тогтвортой санхүүжилтийг хангах зэрэг багтана.

01 **Суралцагч хот байгуулах төлөвлөгөө боловсруулах**

Төлөвлөгөө боловсруулах явцад улс төрийн хүчтэй манлайлал болон тогтвортой хөгжлийн алсын харааг тусгах ёстой.

- Хотын өвөрмөц нөхцөл байдал, сорилт, хөгжлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай гол асуудлуудыг тодорхойлоход хотын захиргаа болон иргэдийн төлөөлөгчдийг оролцуулах.
- Төрөл бүрийн салбар, оролцогч талуудын хэрэгжүүлж буй холбогдох төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаар мэдээлэл цуглуулж, хүрсэн үр дүнгээ дүгнэх.
- Янз бүрийн салбар, оролцогч талуудад чадавх бэхжүүлэх сургалт, семинар зохион байгуулах замаар суралцагч хот гэж юу болох талаарх ойлголт өгөх.
- Тодорхой үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, анхаарал татахуйц, тогтооход хялбар гарчиг өгөх. Энэхүү төлөвлөгөө нь ЮНЕСКО-оос боловсруулсан суралцагч хотуудын шинж чанаруудад үндэслэн дунд болон урт хугацааны зорилт болон тэдгээрийг үнэлэх хяналт-үнэлгээний хэрэглүүр болох юм.
- Хотын нийт иргэдийн суралцах үйл ажиллагааг сайжруулах, НТС-г хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон хотын Дүрэм боловсруулах. Эдгээр арга хэмжээ нь суралцагч нийгмийг бий болгох, боловсролыг дэмжих Засгийн газрын стратегитай уялдах ёстой.

02 **Оролцогч талуудыг хамруулсан зохион байгуулалтын бүтцийг бий болгох**

Нийт иргэд, бүхий л байгууллага, аж ахуйн нэгж суралцагч хотын оролцогч талууд юм. Тиймээс суралцагч хотыг байгуулахад яриа хэлэлцээ, зөвшилцлийн замаар бүх оролцогч талуудыг татан оролцуулсан зохион байгуулалтын бүтцийг бий болгох хэрэгтэй.

- Янз бүрийн салбарын төлөөллөөс бүрдсэн суралцагч хот байгуулах, хөгжүүлэх хороо/ажлын хэсгийг байгуулна. Хороо/ажлын хэсэг нь суралцагч хот байгуулах, хөгжүүлэх, хяналт тавих, санхүүжүүлэх нэгдсэн ойлголт, зарчмыг боловсруулах ёстой.
- Суралцагч хот байгуулах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцогч бүх талуудад тодорхой үүрэг, хариуцлага хүлээлгэж, баталгаажуулах.
- Иргэд хувь нэмрээ оруулж, туршлагаа хуваалцах талбар бүхий суралцагч хотын асуудлаарх форумыг зохион байгуулах.
- Туршлага, мэдлэг, шинэ санаа, сайн туршлага солилцох үндэсний болон олон улсын хэмжээнд бусад хотуудтай харилцаа холбоо тогтоох.
- ЮНЕСКО-ийн СХДС болон бусад сүлжээ, холбоонд нэгдэх.
- Боловсролын яам болон бусад холбогдох яамтай нягт харилцаатай байж иргэдэд үндэсний хөгжлийн талаар мэдээлэл ойлголт өгөх.

03 Баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулж, заншил болгох

Иргэдийн урам зоргийг бадраах нь суралцагч хот амжилттай байгуулах, тогтвортой хөгжүүлэх нэгэн суурь болдог. Суралцагч хот байгуулах санаачилгыг олон хүн, байгууллага эерэгээр хүлээн авч, хамтран ажиллах тусам тэр хэмжээгээр хотын хөгжил хурдтай явагддаг.

- Хүмүүс олноор цуглардаг газруудад эрдэм номын баяр зохион байгуулах. Ийм төрлийн баяр, арга хэмжээнд холбогдох байгууллагуудыг өөрийн сургалт, бүтээгдэхүүн, ном, сурах бичгээ танилцуулж, иргэдийг идэвхтэй оролцохыг уриалах.
- Суралцагч хотын талаар мэдлэг ойлголт өгч, үзэл баримтлалыг танилцуулах чуулга, уулзалтууд зохион байгуулах. 1-2 бусад хотын төлөөллийг урьж оролцуулж, туршлага, мэдлэг, шинэ санаачилгаа хуваалцаарай.
- Боловсрол, суралцахуйг сурталчлах, баяр, арга хэмжээг тэмдэглэхдээ хэвлэл мэдээллийнхнийг урих хэрэгтэй.
- Уламжлал болсон баяр, арга хэмжээг тогтмол зохион байгуулж, оролцогч талуудын хүсэл, сонирхолд нийцүүлэн шинэчлэн зохион байгуулж байх нь мөн зүйтэй.

04 Бүх иргэдийн хүртээмжтэй боловсрол, суралцахуйг хангах

Суралцахуй нь бүх иргэдэд тааламжтай, хүртээмжтэй байснаар тэд насан туршдаа үргэлжлүүлэн суралцах урам зориг, эрч хүчийг олж авах юм.

- Хотод сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлсэн газруудыг газрын зураг дээр тэмдэглэх зэргээр иргэдэд мэдээлэл, заавар, дэмжлэг үзүүлэх.
- Олон нийтийн сургалтын байгууламжийг бий болгох, сурталчлах, өргөжүүлэх, гэр бүл, хамт олны хүрээнд суралцах нөөцөөр хангах.
- Иргэдийн сурч боловсрох хэрэгцээ, сонирхлыг тодорхойлж, хариу арга хэмжээ авах.
- Амьдрах орчноос суралцахуйн үр дүнг тодорхойлох, баталгаажуулах, магадлан итгэмжлэх журам боловсруулах.
- Цагаачид, тусгай хэрэгцээт, ажилгүй иргэд зэрэг тусгаарлагдсан бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх уян хатан зохицуулалт хийх.
- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагыг суралцагч байгууллага болоход чиглүүлж, дэмжлэг үзүүлэх.
- Суралцагчдад/иргэдэд суралцах ээлтэй орчныг хот дотроо бүрдүүлэх.

05 Хяналт-шинжилгээ, үнэлгээний механизмыг бий болгох

Хотын бүх иргэдийн насан туршийн суралцахуйг хангах чиглэлд гарсан ахиц дэвшлийг үнэлэхийн тулд тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чухал.

- Үйл ажиллагааны төлөвлөгөө болон Суралцагч хотын үндсэн шинж чанарт үндэслэн хотын гүйцэтгэл, ахиц дэвшлийг үнэлэн арга барил, хэлбэрийг тодорхойлох.
- Үйл явцыг баримтжуулах, иргэдийн хэрэгцээ, сонирхолыг үнэлэх, мэдээлэл цуглуулах механизмыг бий болгох.
- Суралцагч хотын асуудал хариуцсан хороо/ажлын хэсэг нь сургамж, сайжруулах шаардлагатай чиглэлд санал гаргаж, тогтмол тайлагнах шаардлагатай.
- Бүх оролцогч талуудад мэдээлэл өгөх, санал хүсэлтийг цуглуулах стратеги боловсруулах

06 Тогтвортой санхүүжилтийг хангах

Суралцагч хот байгуулж, тогтвортой хөгжихийн тулд тогтвортой санхүүжилтийн олон эх үүсвэрийг баталгаажуулж, хуваарилах шаардлагатай.

- Суралцагч хот байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний үндсэн бүтцийг шийдвэрлэхэд хангалттай санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх.
- Компани, сан, буяны үйлс, олон улсын түнш донор байгууллагууд, орон нутгийн удирдлага, засгийн газар, үндэстэн дамнасан корпорациуд г.м олон талт түншлэлд суурилсан зардал хуваах механизмыг боловсруулах.
- Бүх оролцогч талуудын санал болгож буй сургалтын нөөцийг үр дүнтэй ашиглах.
- Суралцахуйн үр нөлөөг тодорхойлох, дүн шинжилгээ хийх.
- Орхигдсон бүлэг, хувь хүмүүст чиглэсэн уян хатан, тусгай зохицуулалт хийх.

ЮНЕСКО-ийн СХДС-нд элсэх өргөдөл гаргах журам

- 1.Өргөдөлийн маягтыг ЮНЕСКО-ийн СХДС-ний цахим хуудаснаас^[3] татан авч, англи хэл дээр бөглөнө. Маягтыг цахим хэлбэрээр бөглөж болох ба хотын захирагчийн (засаг дарга) гарын үсэгтэй байна.
- 2.Бөглөсөн маягтыг тухайн улсын ЮНЕСКО-ийн үндэсний комисст илгээн зөвшөөрөл авч, үндэсний комисс нь өргөдлийг, нэр дэвшүүлэх албан захидлын хамт ЮНЕСКО-ийн СХДС-ний Зохицуулалтын багт илгээнэ. Ингэхдээ ЮНЕСКО-ийн үндэсний комисс нь нэмэлт бичиг баримт шаардах боломжтой.
- 3.Өргөдлийг олон улсын шүүгчид хянан үзэж, урьдчилсан дүнг ЮНЕСКО-д хүргүүлнэ. Эцсийн сонгон шалгаруулалтын тухай мэдээг ЮНЕСКО-ийн СХДС-ний Зохицуулалтын баг ЮНЕСКО-ийн үндэсний комисст мэдэгдэнэ.

Нэг улсаас хэдэн хот гишүүнээр элсэх боломжтой вэ?

ЮНЕСКО-ийн үндэсний комисс нь сонгон шалгаруулалтын хугацаанд гурав хүртэлх хотыг ЮНЕСКО-ийн СХДС-нд нэгдэх хүсэлтийг дэмжих боломжтой.

Өргөдөл хэзээ өгөх вэ?

Сүлжээнд нэгдэх сонгон шалгаруулалт хоёр жил тутамд, хоёр сарын хугацаатай зарлагддаг бөгөөд энэ хугацаанд хотууд ЮНЕСКО-ийн үндэсний комисст хүсэлтээ гаргана. Үүний дараа ЮНЕСКО-ийн үндэсний комисс нь дэмжигдсэн өргөдлийг ЮНЕСКО-ийн СХДС-ний Зохицуулах багт нэг сарын хугацаанд багтаан илгээнэ.

Шүүгчдийн бүрэлдэхүүн

Шүүгчдийн бүрэлдэхүүн нь насан туршийн суралцахуй, суралцагч хотын асуудлаарх өргөн мэдлэг, туршлагатай, бие даасан, өндөр түвшний олон улсын шинжээчдээс бүрдэх бөгөөд газарзүйн тархалт, хүйсийг харгалзан үзэж, ЮНЕСКО-ийн Насан туршийн суралцахуйн хүрээлэнгийн (ЮНЕСКО-ийн НТСХ) захирал зургаан жилийн хугацаагаар томилно.

Гишүүнээр элсүүлэх үйл явц

Шүүгчид СХДС-ний гишүүнчлэлийн үзэл баримтлалын дагуу ажил үүрэг, шүүлтийг явуулах бөгөөд ЮНЕСКО-ийн СХДС-ний Нарийн бичгийн дарга нарын газраас томилогдсон албан тушаалтан зөвлөхөөр ажилладаг. Шүүгчдийн зөвлөл мөн дотооддоо даргаа сонгоно. Шийдвэрийг аль болох зөвшилцөж, бусад тохиолдолд энгийн олонхийн санал авах хүртэл нууц санал хураалтаар гаргана.

[3] <https://www.uil.unesco.org/en/learning-cities/members/become-member>

Ашиг сонирхлын зөрчил

ЮНЕСКО-ийн НТСХ-ийн Удирдах зөвлөлийн гишүүд шүүгчээр томилогдох эрхгүй. Бодит эсвэл болзошгүй ашиг сонирхлын зөрчилдөөнтэй шүүгчид хэлэлцүүлэгт оролцохоос татгалзах эсхүл ЮНЕСКО-ийн НТСХ-ийн захирал түдгэлзүүлэх эрхтэй.

Гишүүнчлэлийн хураамж

ЮНЕСКО-ийн СХДС-нд нэгдсэн хотууд гишүүнчлэлийн хураамж төлөх шаардлагагүй. Сүлжээний үйл ажиллагаа, хөгжлийг дэмжихийн тулд ЮНЕСКО-ийн СХДС-ний Зохицуулах баг гишүүдийн сайн дурын санхүүгийн болон санхүүгийн бус хандивыг талархан хүлээж авдаг.

ЮНЕСКО-ийн СХДС-ний Зохицуулах багтай харилцах

Сүлжээний гишүүн хотууд өөрийн хотын талаарх шинэ мэдээллийг (тухайлбал шинэ хотын дарга, зохицуулагч, ажлын хэсэг, хотын шинэ стратеги, төлөвлөгөө, сүлжээний хүрээнд зохион байгуулж буй арга хэмжээ г.м) ЮНЕСКО-ийн СХДС-ний Зохицуулах багт цахим шуудангаар цаг тухай бүрт мэдэгдэж байх ёстой.

Суралцагч хотын ахиц дэвшил, явцын тайланг хүргүүлэх

Гишүүн хотууд суралцагч хот байгуулах төслөө хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар дэлгэрэнгүй тайлагнах шаардлагатай. Уг тайлан нь бодлого, стратеги, арга хэмжээ, түншлэл, ахиц дэвшлийг үнэлэж, гишүүн хотуудын ололт амжилтыг хянахад ихээхэн хэрэгтэй юм. Тайланг ЮНЕСКО-ийн СХДС-ний Зохицуулах багын боловсруулсан загварыг ашиглан боловсруулж (Сүлжээнд нэгдэх сонгон шалгаруулалт хоёр жил тутамд, хоёр сарын хугацаатай зарлагддаг бөгөөд энэ хугацаанд хотууд ЮНЕСКО-ийн үндэсний комисст хүсэлтээ гаргана. Үүний дараа ЮНЕСКО-ийн үндэсний комисс нь дэмжигдсэн өргөдлийг ЮНЕСКО-ийн СХДС-ний Зохицуулах багт нэг сарын хугацаанд багтаан илгээнэ.) хоёр жил тутамд Learncities@unesco.org цахим хаягаар хүргүүлнэ.

Тайланг хянах, сүлжээнээс хасах

ЮНЕСКО-ийн СХДС-ний Зохицуулах баг сүлжээний үзэл баримтлал, дүрэм журамд үндэслэн гишүүн хотуудын явцын тайланг хянаж, үнэлнэ. Дараах тохиолдолд гишүүн хотуудыг сүлжээнээс хасах эрхтэй.

Үүнд:

- 1.Хэрэв гишүүн хот ахиц дэвшлийн тайланг дутуу ирүүлсэн бол
- 2.Суралцагч хот байгуулах аливаа ахиц дэвшлийг гаргаагүй ба/эсхүл
- 3.Хоёр жил тутамд өгөх ахиц дэвшлийн тайлангаа ирүүлээгүй тохиолдолд.

Сүлжээнээс гарсан тохиолдолд ЮНЕСКО-ийн СХДС-нд элсэх өргөдлийн хугацаанд сүлжээнд дахин нэгдэх хүсэлт гаргаж болно.

Суралцагч хотын шалгуур үзүүлэлтүүд

| | |
|--|--|
| Суралцагч хотын төлөвлөлт | <ul style="list-style-type: none"> • Суралцагч хотын дунд (3-5 жил) болон урт (5-10 жил) хугацааны төлөвлөгөө • Суралцагч хотын стратегид тогтвортой хөгжил, эрүүл мэндийн асуудал хэрхэн тусгагдсан эсэх • Суралцагч хотын стратегид үл алагчилсан байдал, тэгш хамруулалт хэрхэн тусгагдсан эсэх • Суралцагч хотын стратегид хөдөлмөр эрхлэлт, хувийн бизнес эрхлэх асуудал хэрхэн тусгагдсан бэ |
| Оролцогч талуудын үүрэг, оролцоо | Суралцагч хотын асуудал хариуцсан ажлын хэсэг, зохицуулалтын баг, бүлэг байгуулагдсан эсэх |
| Нөөц бүрдүүлэлт | <p>Суралцагч хот байгуулах санхүүгийн болон санхүүгийн бус нөөц бүрдүүлэлт</p> <ul style="list-style-type: none"> • Санхүүгийн: улсын төсөв, донор байгууллагуудын хөрөнгө оруулалт, хувийн байгууллагуудын хөрөнгө оруулалт г.м. • Санхүүгийн бус: олон нийтийн төв, номын сан, сайн дурын байгууллага, соёлын төв, судлаач, шинжээчдийн баг г.м. |
| Бүх нийтийн суралцах эрхийг хангасан байдал | <ul style="list-style-type: none"> • Насан туршийн суралцахуйн хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн эмзэг бүлгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, боловсролд хамрагдалтад тулгарч буй саад бэрхшээлийг шийдвэрлэх бодлого, стратеги, санаачилга • Хотын оршин суугчдад сурч, боловсрох боломж, нөөцийн талаарх мэдээллийг хэрхэн хүргэдэг вэ? Тухайлбал: олон нийтийн сургалтын төв, дижитал сургалтын хэрэглүүр, сургалтын аппликейшн зэрэг |
| Суралцагч хот байгуулах, урт хугацаанд тогтвортой үргэлжлүүлэхийн тулд зохион байгуулж буй аливаа алга хэмжээ, тэмдэглэлт өдрүүд | <ul style="list-style-type: none"> • Боловсрол, суралцахуйг тэмдэглэх ямар нэгэн тэмдэглэл өдрүүд, тогтсон арга хэмжээ байгаа эсэх • Насан туршийн суралцахуйг тэмдэглэх хотын хамгийн том арга хэмжээ, тэмдэглэлт өдөр • Уг тэмдэглэлт өдрүүд, арга хэмжээний үр дүн |
| Суралцагч хотын хөгжлийн хяналт үнэлгээний тогтолцоо | <ul style="list-style-type: none"> • Хяналт үнэлгээний ажлын хэсэг байгуулагдсан эсэх • Хөгжлийн индикатор, зорилтот түвшин • Хөгжлийн индикатор, зорилтот түвшин НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд болон ЮНЕСКО-оос тогтоосон СХДС-ний гол шинж чанаруудтай уялдаж байгаа эсэх |
| Суралцагч хотын сайн туршлага | <ul style="list-style-type: none"> • Тухайн суралцагч хот насан туршийн суралцахуйг өргөжүүлж буйг илтгэх сайн туршлага, төсөл, хөтөлбөр, флагшип төслүүд Эдгээр төсөл, хөтөлбөрүүдийн нийгэм, соёл, байгаль орчинд үзүүлсэн эерэг нөлөө |
| ЮНЕСКО-ийн СХДС | <ul style="list-style-type: none"> • ЮНЕСКО-ийн СХДС-нд нэгдсэнээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл • ЮНЕСКО-ийн СХДС-нд үзүүлэх хувь нэмэр |

ЮНЕСКО-ийн Суралцагч хотуудын дэлхийн сүлжээ ТОВЧООР

Алсын хараа

Бүх нийтийн насан туршийн боловсрол бол манай хотын ирээдүй

Эрхэм зорилго

Сүлжээний гишүүн хотуудын хамтын ажиллагаа, бие биеэсээ суралцах, бодлогын яриа хэлэлцээг өргөжүүлэх замаар насан туршийн суралцахуйг хөгжүүлэх; түншлэлийг дэмжих; чадавх бэхжүүлэх; суралцагч хотуудын хөгжил дэвшлийг урамшуулах, үнэлэх арга хэрэгслийг боловсруулах

Суурь баримт бичгүүд

- Суралцагч хотуудыг байгуулах тухай Бээжингийн тунхаглалаар хотуудын хөгжил цэцэглэлт, тогтвортой байдлыг дэмжихэд насан туршийн суралцахуйн гүйцэтгэх үүргийг тодорхойлж, суралцагч хотуудыг байгуулах үүрэг амлалтуудыг баталсан;
 - “Суралцагч хотуудын үндсэн шинж чанарууд” удирдамж нь суралцагч хотуудын хүрээ, ахиц дэвшлийг үнэлэх, сайжруулах арга хэмжээний жагсаалтыг багтаасан.
-

Суралцагч хот

ЮНЕСКО-ийн СХДС нь хөгжлийн янз бүрийн үе шатанд буй хотуудаас бүрддэг. ЮНЕСКО-ийн СХДС-ний түнш болон Нарийн бичгийн дарга нарын газар нь чухал хувь нэмэр, үүрэг оролцоотой ажилладаг.

Нарийн бичгийн дарга нарын газар

ЮНЕСКО-ийн СХДС-ний НБДГ сүлжээний үйл ажиллагааг зохицуулдаг. НБДГ нь насан туршийн суралцахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх мандаттай НҮБ-ын цор ганц нэгж болох ЮНЕСКО-ийн Насан туршийн боловсролын хүрээлэнд (UIL) байрладаг.

Хавсралт 1. Суралцагч хотын үндсэн шинж чанарууд ба үнэлгээний аргачлал

| Чиглэл | Шинж чанар | Боломжит үнэлгээ | Эх сурвалж | Үр дүн |
|---|---|--|--|----------------------------------|
| 1. Суралцагч хот байгуулахын өргөн хүрээний ач холбогдол | | | | |
| 1.1 Хувь хүнийг чадавхижуулах, нийгмийн эв нэгдлийг дэмжих | 1.1.1 Иргэн бүр бичиг үсэгт тайлагдах, нийтлэг ур чадвар эзэмших боломжийг бүрдүүлэх | Насанд хүрэгчдийн бичиг үсгийн түвшин: 15 ба түүнээс дээш насны бичиг үсэг тайлагдсан иргэдийн нийт тоо, тухайн насны бүлгийн нийт хүн амын хувиар илэрхийлнэ. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | Эрэгтэй % Эмэгтэй % Нийт % |
| | 1.1.2. Иргэдийг нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломжийг олгох, урамшуулах | Сонгуульд оролцох хувь: Сүүлийн хугацаанд болсон томоохон сонгуульд оролцох насны иргэдийн оролцооны түвшин. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | % (Жилийн |
| | | Сайн дурын болон олон нийтийн үйл ажиллагаанд хамрагдалт: Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд сайн дурын болон олон нийтийн үйл ажиллагаанд цалин урамшуулалгүй хамрагдсан иргэдийн тоо | Судалгааны дүн | % |
| | 1.1.3 Жендэрийн тэгш байдлыг хангах | Улс төрийн оролцоо ба жендэрийн тэгш байдал: Парламент дахь эмэгтэйчүүдийн хувь. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | % |
| | | Бизнес эрхлэгчдийн жендэрийн харьцаа: Шилдэг 10 аж ахуйн нэгжийн эмэгтэйчүүдийн эзлэх хувь. | Судалгааны дүн | % |

| | | | | |
|---|--|--|--|----------------------------------|
| | 1.1.4 Аюулгүй, эв найртай, хүртээмжтэй нийгэмлэгийг бий болгох | Гэмт хэргийн түвшин: 100,000 хүн амд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | % |
| | | Нийгмийн статусын өөрчлөлт: Хүүхдээ өөрөөсөө илүү нийгэмд эзлэх байр суурь эзэлнэ гэдэгт итгэдэг амьжиргааны түвшин доогуур иргэдийн хувь. | Судалгааны дүн | % |
| 1.2 Эдийн засгийн хөгжил ба соёлын цэцэглэлт | 1.2.1 Эдийн засгийн хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг дэмжих | Нэг хүнд ногдох ДНБ | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | ам.доллар |
| | | Ядуурлын түвшин: 2005 оны олон улсын ханшаар өдөрт 1.25 ам. доллараас бага зардлаар амьдардаг иргэдийн хувь | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | % |
| | 1.2.2 Бүх иргэдийг ажлын байраар хангах боломжийг бүрдүүлэх | Ажилгүйдлийн түвшин: Ажилгүй хөдөлмөрийн насны хүн ам (15 ба түүнээс дээш). | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | Эрэгтэй % Эмэгтэй % Нийт % |
| | 1.2.3 Шинжлэх ухаан, технологи, инновацийг дэмжих | Шинжлэх ухаан, технологийн салбарын хүний нөөц: Шинжлэх ухаан, технологийн салбарт ажилладаг мэргэжилтнүүдийн нийт ажил эрхлэлтийн хувь. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | % |
| | | Оюуны өмч: 100,000 хүн амд ногдох шинэ патентын тоо. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | Тоо |
| | 1.2.4 Соёлын олон төрлийн үйл ажиллагаанд оролцох боломжийг хангах | Соёлын арга хэмжээнд хамрагдалтын түвшин: Нэг сард музей, театр, кино театр, концертын танхим, спортын арга хэмжээнд зочилсон хүний тоо. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | Тоо |

| | | | | |
|---|---|--|--|---|
| | 1.2.5 Чөлөөт цаг зөв зохистой өнгөрүүлэх, бие бялдар хөгжүүлэхийг дэмжих | Биен тамир, спортоор хичээллэх: Долоо хоногт таваас доошгүй удаа биен тамирын дасгал, спортоор хичээллэдэг хүн амын эзлэх хувь | Судалгааны дүн | % |
| 1.3 Тогтвортой хөгжлийг дэмжих | 1.3.1 Эдийн засгийн өсөлт болон иргэдээс хамаарсан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах | Нүүрс хүчилтөрөгч (CO2) ялгаруулалт: Нэг хүнд ногдох нийт CO2 ялгаруулалт, тонноор. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл эсвэл судалгааны дүн | % |
| | | Хог хаягдлын менежмент: нэг хүнд ногдох жилийн хогийг цуглуулж, боловсруулсан ахуйн хог хаягдлыг кг-аар тооцох. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл эсвэл судалгааны дүн | Тонн |
| | 1.3.2 Хотын амьдрах орчныг сайжруулах | Амьдрах нөхцөл: ядуусын хороололд амьдардаг хүн амын хувь | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл эсвэл судалгааны дүн | ? |
| | | Нийтийн тээвэр: Нийтийн тээврийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханаамж | Судалгааны дүн | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | 1.3.3 Бүхий л орчинд идэвхтэй суралцах замаар тогтвортой хөгжлийг дэмжих | Тогтвортой хөгжлийн боловсрол: Боловсролын бүх түвшинд тогтвортой хөгжлийг дэмжих үр дүнтэй арга хэмжээ | Мэргэжилтнүү дийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | | Байгаль орчны менежмент: Байгаль орчны хариуцлагын талаар иргэдийн өөрсдийн зан үйлийн талаарх ойлголт. | Судалгааны дүн | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |

2. Суралцагч хот байгуулах суурь зарчмууд

| | | | | |
|--|--|---|--|--|
| 2.1 Боловсролын хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх | 2.1.1. Бага насны хүүхдийн асаргаа, боловсролын хүртээмжийг сайжруулах | Сургуулийн өмнөх боловсролын элсэлт: Сургуулийн өмнөх боловсролын элсэлтийн хувь. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | 2.1.2 Багаас дээд шат хүртэлх боловсролын хүртээмжийг өргөжүүлэх | Сургуульд сурсан дундаж жил: 25 ба түүнээс дээш насны хүмүүсийн албан ёсны боловсрол эзэмшсэн дундаж жил. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | 2.1.3 Насанд хүрэгчдийн боловсрол, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын хүртээмж, оролцоог нэмэгдүүлэх | Насанд хүрэгчдийн сургалт, боловсрол: Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд боловсрол/сургалтад хамрагдсан 25-64 насны иргэдийн хувь. | Судалгааны дүн | % |
| | 2.1.4 Боловсролын хүртээмжийг хангах үүднээс гадуурхагдсан бүлэг, цагаач гэр бүлүүдэд дэмжлэг үзүүлэх | Нийгмийн эмзэг бүлгийнхэнд үзүүлэх дэмжлэг: Өөр орны болон эмзэг бүлгийн суралцагчдыг дэмжих зорилгоор хотын удирдлагуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ. | Мэргэжилтнү үдийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | | Ахмад настнуудад үзүүлэх дэмжлэг: Ахмад настнуудад (65 ба түүнээс дээш насны) дэмжлэг үзүүлэх зорилгоор хотын захиргаанаас авсан арга хэмжээ. | Мэргэжилтнү үдийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |

| | | | | |
|--|--|--|---|--|
| 2.2 Гэр бүл, хамт олны хүрээллээс суралцахуйг дэмжих | 2.2.1 Олон нийтэд түшиглэсэн сургалтын орон зайг бий болгож, гэр бүл, хамт олноороо суралцах нөөцөөр хангах | Дэд бүтэц: 100,000 хүнд ногдох сургалтын байгууллагууд (олон нийтийн сургалтын төв, соёлын ордон, нийтийн номын сан). | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | |
| | | Гэр бүлээрээ суралцахыг дэмжих бодлого: Гэр бүлээрээ суралцахыг дэмжих бодлого байгаа эсэх. | Мэргэжилтнү үдийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | 2.2.2 Иргэдийг гэр бүл, олон нийтээрээ мэдлэг, боловсролтой болохыг дэмжих | Олон нийтийн сургалтын хамрагдалт: Олон нийтийн сургалтын үйл ажиллагаанд тогтмол оролцож буй иргэдийн хувь (долоо хоногт 2 цагаас багагүй). | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | % |
| | | Гэр бүлээрээ сургалтанд хамрагдах: Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд гэр бүлээрээ хамтран суралцсан иргэдийн хувь. | Судалгааны дүн | % |
| | 2.2.3 Түүх, соёл, уламжлал танин мэдэхүйн арга барилыг хосгүй үнэт баялаг хэмээн хүлээн зөвшөөрөх | Уугуул иргэдийн мэдлэгээр дамжуулан сургалтын нөөцийг хөгжүүлэх: Хотын захиргаанаас боловсруулсан түүх, соёл, уугуул иргэдийн мэдлэгт суурилсан сургалтын хөтөлбөрийн тоо. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | |
| | 2.3 Ажлын байранд болон ажилд ороход шаардлагатай мэдлэг, ур чадварт суралцахад нь дэмжлэг үзүүлэх | 2.3.1 Ажиллах хүчин, тэр дундаа цагаач ажилчдад суралцах боломж олгох. | Ажилчдын сургалтад хамрагдалт: Хөдөлмөр эрхэлж буй иргэдийн ажлын байран дахь сургалтад хамрагдах түвшин. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл |
| Цагаач ажилчдын сургалтад хамрагдалт: Цагаач ажилчдын сургалтад хамрагдалтыг дэмжих зорилгоор хотын захиргаанаас хэрэгжүүлсэн болого, санаачилга, стратеги байгаа эсэх | | Мэргэжилтнү үдийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу | |

| | | | | |
|---|--|---|--|--|
| 2.3 Ажлын байранд болон ажилд ороход шаардлагатай мэдлэг, ур чадварт суралцахад нь дэмжлэг үзүүлэх | 2.3.2 Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг суралцагч байгууллага болоход нь дэмжих | Суралцагч байгууллагууд: Ажилчдыг сургалтад оролцохыг дэмжсэн санаачилга эсвэл стратеги байгаа эсэх. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | 2.3.3 Ажил олгогч, үйлдвэрчний эвлэлээс ажлын байран дахь суралцахуйг дэмжих бодлого | Ажил олгогчид ажилчдын ур чадварыг хөгжүүлэхэд оруулж буй хөрөнгө оруулалт: Төрийн болон хувийн байгууллагууд ажилчдын боловсрол, сургалтад оруулж буй нийт хөрөнгө оруулалт (мөнгөн) | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | Төр % Хувийн хэвшил % |
| | 2.3.4 Хөдөлмөр эрхэлдэггүй залуучууд болон насанд хүрэгчдэд тохирсон суралцахуйг дэмжих | Боловсрол эзэмшсэн, хөдөлмөр эрхэлж буй залуучуудын түвшин: Боловсрол эзэмшээгүй, сургалтад хамрагдаагүй, хөдөлмөр эрхэлдэггүй залуучуудын нийт (15-24 насны) эзлэх хувь. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | % |
| | | Ажилгүй иргэдэд чиглэсэн сургалт: Хөдөлмөр эрхэлхэд шаардлагатай ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамрагдсан ажилгүйчүүдийн хувь. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | % |
| 2.4 Орчин үеийн сургалтын технологийн хэрэглээг өргөжүүлэх | 2.4.1 Сургуулийн захиргаа, багш, сурган хүмүүжүүлэгчдэд сургалтыг сайжруулах дэвшилтэд техник, технологийг ашиглах сургалт орох | Захиргаа, багш, сурган хүмүүжүүлэгчдэд зориулсан МХХТ-ийн сургалт: Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд МХХТ-ийн сургалтад хамрагдсан багш/сурган хүмүүжүүлэгчдийн хувь | Судалгааны дүн | Сургууль % сургалтын байгуулам ж % |

| | | | | |
|---|--|---|--|--|
| 2.4 Орчин үеийн сургалтын технологийн хэрэглээг өргөжүүлэх | 2.4.2 Иргэдийн цахим хэрэглүүрийн хүртээмж, сургалтын хөтөлбөрт хамрагдах боломжийг өргөжүүлэх | Сургалтад МХХТ-ийг ашиглах: Сургалтын хөтөлбөрт МХХТ-ийг тогтмол ашигладаг багш/сурган хүмүүжүүлэгчдийн хувь. | Судалгааны дүн | Сургууль % сургалтын байгууламж % |
| | | Гар утастай иргэдийн тоо: Гар утастай хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувь. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | % |
| | | Интернэтийн хэрэглээ: Өрхийн болон дундын интернет ашиглах боломжтой иргэдийн хувь. Цахимаар суралцах: Иргэдийн интернэт ашиглан суралцдаг дундаж цаг (долоо хоногт) | Судалгааны дүн | % |
| 2.5 Сургалтын чанарыг сайжруулах | 2.5.1 Боловсрол, суралцахуйн тогтолцооны өөрчлөлтийг дэмжих | Боловсрол, суралцахуйн тогтолцооны өөрчлөлт: багшлахуйгаа суралцахуйд шилжсэн, зөвхөн мэдээлэл олж авахаас илүүтэй бүтээлч байдал, суралцах чадварыг хөгжүүлэх шилжилтийг дэмжих боловсролын бодлого. | Мэргэжилтнүүдийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | 2.5.2 Нийтийн ёс суртахуун, соёлын үнэт зүйлсийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, ялгаатай байдлыг ойлгуулах, хүлээн зөвшөөрөх мэдлэг олгох | Хамтран амьдрахад суралцах: Бусад зан заншил, соёлтой хүмүүстэй тогтмол харьцсан иргэдийн хувь. | Судалгааны дүн | % |
| | 2.5.3 Зохих ёсоор бэлтгэгдсэн багш/сурган хүмүүжүүлэгчийн хүрэлцээ: Сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд, насанд хүрэгчдийн боловсролын багш суралцагчдын харьцаа. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу | |
| | 2.5.4 Суралцагчдад ээлтэй орчныг бүрдүүлэх | Суралцагчдад ээлтэй орчин: Сурагчдын сурах орчиндоо сэтгэл хангалуун байгаа эсэх. | Судалгааны дүн | Сургууль % Сургалтын байгууллага |

| | | | | |
|--|---|---|--------------------------|--|
| 2.6 Насан туршийн суралцахуй соёлыг төлөвшүүлэх | 2.6.1 Суралцахуйг урамшуулах, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах, дэмжих | Суралцахуйг хөхиүлэн дэмжих: Олон нийтийн үйл ажиллагаа (насанд хүрэгчдийн суралцахуйн долоо хоног, эрдмийн баяр г.м) байгаа эсэх, мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр суралцахуйг хөхиүлэн дэмжиж, сурталчилдаг эсэх. | Мэргэжилтнүүдийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | 2.6.2 Бүх иргэдэд хангалттай мэдээлэл, зааварчилгаа, дэмжлэг үзүүлж, тэднийг янз бүрийн арга замаар суралцахад нь урамшуулах | Мэдээлэл, үйлчилгээ: Мэдээлэл, зөвлөгөө өгөхөд сэтгэл хангалуун байгаа суралцагчдын хувь. | Судалгааны дүн | |
| | 2.6.3 Сургалтын бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрч, урамшуулдаг тогтолцоог хөгжүүлэх | Сургалтын үр дүнг урамшуулах: Сургалтын бүх үр дүнг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах бодлого, практик байгаа эсэх. | Мэргэжилтнүүдийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |

3. Суралцагч хот байгуулах суурь нөхцөл

| | | | | |
|--|--|--|--------------------------|--|
| 3.1 Улс төрийн хүсэл зориг, тууштай байдлыг бэхжүүлэх | 3.1.1 Улс төрийн хүчтэй манлайллыг харуулах, хотуудаа суралцагч хот болгохын төлөө тууштай бодлого баримтлах | Манлайлал: Суралцагч хотыг хөгжүүлэх стратеги боловсруулах, хэрэгжүүлэхэд манлайлал, тууштай байдлыг харуулах. | Мэргэжилтнүүдийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | 3.1.2 Бүх нийтийн насан туршийн суралцахуйг дэмжих судалгаа болон оролцоонд суурилсан стратеги боловсруулж, хэрэгжүүлэх | Төрийн бодлого, стратеги: НИТХ-аас баталсан "Бүх нийтийн насан туршийн суралцахуй"-г дэмжих хууль тогтоомж, төрийн бодлого, стратеги. | Мэргэжилтнүүдийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | 3.1.3 Суралцагч хот байгуулах үйл явцыг хянах | Явцын үнэлгээ: Суралцагч хотын стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх явцад гарсан ахиц дэвшилд хяналт тавих зорилгоор хотын захиргаанаас авсан арга хэмжээ. | Мэргэжилтнүүдийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |

| | | | | |
|--|---|---|--|--|
| 3.2 Засаглал, оролцогч талуудын оролцоог сайжруулах | 3.2.1 Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийг татан оролцуулах, салбар хоорондын зохицуулалтын механизмыг бүрдүүлэх | Оролцогч талуудын зохицуулалтын механизм: Суралцагч хотыг хөгжүүлэхэд оролцогч талуудыг дайчлах зохицуулалтын механизмын үр дүн | Мэргэжилтнүү дийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | 3.2.2 Чанартай боловсрол олгох, суралцагч хот байгуулахад өөрсдийн хувь нэмрийг оруулахад бүх оролцогч талуудыг уриалах. | Оролцогч талуудын үүрэг, оролцоо: Илүү чанартай, хүртээмжтэй суралцах боломжоор хангах чиглэлд оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг, амлалт, төлөвлөгөө, үйл ажиллагаа | Мэргэжилтнүү дийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | | Хувийн хэвшлийн үүрэг амлалт: Суралцагч хот байгуулах стратегийг хэрэгжүүлэх хот болон хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа байгаа эсэх. | Мэргэжилтнүү дийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| 3.3 Нөөцийг дайчлах, чадварыг нэмэгдүүлэх | 3.3.1. Засгийн газраас насан туршийн суралцахуйд илүү их хөрөнгө оруулалт хийх | Боловсролын салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалт: Боловсролын салбарт зарцуулсан төсвийн хотын нийт төсөвт эзлэх хувь | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | % |
| | | Төрийн боловсролын зардлын хуваарилалт: Боловсролын янз бүрийн түвшин/төрөлд зарцуулсан төрийн зардлын төсөв. | Хотын захиргаанаас өгсөн албан ёсны мэдээлэл | Суурь боловсрол % Насанд хүрэгчдийн болон Тасралтгүй боловсрол % |
| | 3.3.2 Бүх оролцогч талуудын нийлүүлж буй сургалтын нөөцийг үр дүнтэй ашиглах, зарцуулах, бүх нийтийн насан туршийн суралцахуйг дэмжих | Нөөцийн үр дүнтэй зарцуулалт: Иргэдийн боловсролыг дээшлүүлэхийн тулд санхүүгийн, соёлын болон бусад нөөцийг ашиглах шинэлэг арга замууд байгаа эсэх | Мэргэжилтнүү дийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |

| | | | | |
|--|---|---|--------------------------|---|
| | 3.3.3 Ядуурлын эсрэг бодлогыг баталж, эмзэг бүлэгт дэмжлэг үзүүлэх | Нийгмийн эмзэг бүлгийнхэнд зарцуулах хөрөнгө оруулалт: Нийгмийн эмзэг бүлгийнхний суралцахууд дэмжлэг үзүүлэх хөрөнгийн хуваарилалт, эдгээрийн үр дүнтэй зарцуулалт. | Мэргэжилтнүүдийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |
| | 3.3.4. Иргэд, оршин суугчдыг өөрсдийн авьяас, ур чадвар, мэдлэг, туршлагаа сайн дураараа бусадтай хуваалцахыг дэмжих | Суралцахууд иргэдийн өөрсдийн оруулах хувь нэмэр: Судалгаанаас өмнөх 12 сарын хугацаанд сард дор хаяж нэг удаа бусад иргэдэд суралцахад нь туслахын тулд ур чадвар, мэдлэг, туршлагаа хуваалцсан иргэдийн хувь. | Судалгааны дүн | % |
| | 3.3.5 Хотуудын хооронд санал, туршлага солилцоог дэмжих | Олон улсын хамтын ажиллагаа: Бусад суралцагч хотуудтай олон улсын түншлэл, туршлага солилцоо явуулах | Мэргэжилтнүүдийн дүгнэлт | 5 4 3 2 1 Төгс Маш сайн Сайн Дундаж Муу |

Хавсралт 2. Суралцагч хотуудын үндсэн шинж чанар ба Тогтвортой хөгжлийн зорилгууд



Дараах хүснэгтэд суралцагч хотын үндсэн шинж чанар, хүрэх түвшин, индикатор болон тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ) ба шалгуур үзүүлэлтүүдийн хоорондын уялдаа холбоог жишээн дээр харуулсан болно.

| | | |
|--|---|--|
| <p>Үндсэн шинж чанар: 1.1.1 Хувь хүнийг чадавхжуулах, нийгмийн эв нэгдлийг нэмэгдүүлэх индикатор: Насанд хүрэгчдийн бичиг үсгийн түвшин - 15 ба түүнээс дээш насны бичиг үсэг тайлагдсан иргэдийн нийт тоо, тухайн насны бүлгийн нийт хүн амын хувиар илэрхийлнэ.</p> | <p>ТХЗ-4: 4.6 Бүх залуус, насанд хүрэгчид, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дийлэнх хувь нь бичиг үсэгт тайлагдаж, тоо тоололд суралцсан байх. 4.6.1 Өгөгдсөн насны бүлгийхний бичиг үсэг, тоо тооллын чадвар нь хамгийн багадаа хэрэглээний тогтсон түвшинд хүрсэн иргэдийн хувь, хүйсээр</p> | <p>ТХЗ-16: 16.7 Бүх түвшинд хурдан шуурхай, бүх талын оролцоог хангасан, оролцооны аргад тулгуурласан, төлөөллийн шийдвэр гаргадаг болох 16.7.2 Шийдвэр гаргалт нь хүртээмжтэй, хариуцлагатай байдагт итгэдэг хүн амын эзлэх хувь, хүйсээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй хүн амаар, хүн амын бүлгээр</p> |
| <p>Үндсэн шинж чанар: 1.1.3 Жендэрийн тэгш байдлыг хангах: Бизнесийн удирдлага дахь жендэрийн тэгш байдал - Top 10 аж ахуйн нэгжийн ТУЗ-д эмэгтэйчүүдийн эзлэх суудлын хувь.</p> | <p>ТХЗ-4: 4.5 боловсролын байгууллагад суралцагсдын жендэрийн зохистой харьцааг хангаж, эмзэг бүлэг, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нутгийн уугуул хүмүүс, эмзэг бүлгийн хүүхдүүдэд бүх шатны боловсрол, мэргэжлийн сургалтыг тэгш авах боломжийг бүрдүүлэх 4.5.1 Энэ жагсаалтад орсон боловсролын бүх үзүүлэлтүүдээр задлан гаргаж болох Тэнцвэрийн индекс (эрэгтэй/эмэгтэй, хот/хөдөө орон нутгийн, баян чинээлэг/ядуу, доогуур орлоготой бүлэг болон хөгжлийн бэрхшээлтэй, мөргөлдөөнд өртсөн гэх зэрэг мэдээлэл өгөх боломжтой бусад үзүүлэлтээр)</p> | <p>ТХЗ-5: 5.5 Улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хүрээнд шийдвэр гаргах бүх үе шатанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор эмэгтэйчүүдийг хангах 5.5.1 Парламент, орон нутгийн эрх барих хуралд суудалтай эмэгтэйчүүдийн эзлэх хувь</p> |

| | | |
|---|---|--|
| <p>Үндсэн шинж чанар: 1.3.1 Эдийн засгийн өсөлт болон иргэдээс хамаарсан байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах</p> <p>Хог хаягдлын менежмент: нэг хүнд ногдох жилийн хогийг цуглуулж, боловсруулсан ахуйн хог хаягдлыг кг-аар тооцох.</p> | <p>ТХЗ-11: 11.6 агаарын чанар, хотын болон хог хаягдлын менежментийн асуудалд онцгой анхаарлаа хандуулах замаар хотуудын нэг хүнд ногдох байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах 11.6.1 Хот суурин газарт тогтмол цуглуулдаг хатуу хог хаягдал, түүнээс хот суурин газарт бий болсон хатуу хог хаягдлаас эцсийн боловсруулалт хийгдсэн хатуу хог хаягдын эзлэх хувь, хотоор</p> | <p>ТХЗ-12: 12.5 хог хаягдлаас сэргийлэх, түүнийг бууруулах дахин боловсруулах, дахин хэрэглэх замаар хог хаягдал бий болгож буй хэмжээг үлэмж хэмжээгээр бууруулах 12.5.1 Хог хаягдлын дахин боловсруулалтын үндэсний түвшин, дахин боловсруулсан материал, тонноор.</p> |
| <p>Үндсэн шинж чанар: 2.2.3 Түүх, соёл, уламжлал танин мэдэхүйн арга барилыг хосгүй үнэт баялаг хэмээн хүлээн зөвшөөрөх</p> <p>Уугуул иргэдийн мэдлэгээр дамжуулан сургалтын нөөцийг хөгжүүлэх: Хотын захиргаанаас боловсруулсан түүх, соёл, уугуул иргэдийн мэдлэгт суурилсан сургалтын хөтөлбөрийн тоо</p> | <p>ТХЗ-4: 4.7. тогтвортой хөгжлийн мэдлэг, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендерийн тэгш байдал, энх тайван болон хүч үл хэрэглэх соёлыг төлөвшүүлэх, дэлхийн иргэн байх, соёлын олон янз байдал болон тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмрийг ойлгуулах мэдүүлэх замаар тогтвортой хөгжлийг хөхүүлэх дэмжихэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг бүх суралцагчдад олгох 4.7.1 (i) Дэлхийн иргэний боловсрол жендерийн тэгш байдал, хүний эрхийн асуудлыг хамруулсан (ii) тогтвортой хөгжлийн боловсролыг (a) үндэсний боловсролын бодлого, (b) сургалтын хөтөлбөр, (c) багш нарын боловсрол болон (d) суралцагчийн үнэлгээнд тусгасан байдал</p> | <p>ТХЗ-11: 11.4 Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хадгалан хамгаалах арга хэмжээг сайжруулах 11.4.1 Үндэсний соёл, байгалийн өвийг хадгалах, хамгаалахад зарцуулсан нэг хүнд ногдох нийт зардлын хэмжээ (төрийн болон хувийн), өвийн төрлөөр (Дэлхийн өвийн төв байгууллагын тодорхойлсноор соёлын, байгалийн, холимог гэх зэрэг), зардлын төрлөөр (үйл ажиллагааны зардал болон хөрөнгө оруулалт), хувийн санхүүжилтийн төрлөөр (биет болон биет бус хувийн ашгийн бус байгууллагад өгч буй хандивын төрөл, ивээн тэтгэгч), засаг захиргааны нэгжийн түвшинд</p> |
| <p>Үндсэн шинж чанар: 2.3.4 Хөдөлмөр эрхэлдэггүй залуучууд болон насанд хүрэгчдэд тохирсон суралцахуйг дэмжих</p> <p>Боловсрол эзмэшсэн, хөдөлмөр эрхэлж буй залуучуудын түвшин: Боловсрол эзэмшээгүй, сургалтад хамрагдаагүй, хөдөлмөр эрхэлдэггүй залуучуудын нийт (15-24 насны) эзлэх хувь.</p> | <p>ТХЗ-4: 4.3 бүх эрэгтэй, эмэгтэй хүнд хямд үнэтэй, чанартай техникийн, мэргэжлийн болон дээд боловсрол, түүний дотор их дээд сургуулийн боловсролыг тэгш авах боломжийг бүрдүүлэх 4.3.1 Сүүлийн 12 сарын хугацаанд албан болон албан бус боловсрол, сургалтад хамрагдсан насанд хүрэгчид, залуучуудын эзлэх хувь, хүйсээр</p> | <p>ТХЗ-8: 8.6 2020 он гэхэд ажил эрхэлдэггүй, боловсрол эсвэл сургалтад хамрагдаагүй залуучуудын эзлэх хувийг үлэмж хэмжээгээр бууруулах 8.6.1 Боловсрол эзэмшээгүй, хөдөлмөр эрхлээгүй болон сургалтад хамрагдаагүй 15-24 насны залуучуудын эзлэх хувь</p> |

Эх сурвалж

1. **Beijing Declaration on Building Learning Cities & Key Features of Learning Cities (2013)** Холбоос:

<http://unesdoc.unesco.org/images/0023/002349/234986e.pdf>

2. **Mexico City Statement on Sustainable Learning Cities (2015)** Холбоос:

<http://www.uil.unesco.org/fileadmin/keydocuments/LifelongLearning/learning-cities/en-mexico-city-statement-on-sustainable-learning-cities.pdf>

3. **3x3x3 Youth Statement on Learning Cities (2015)** Холбоос:

http://www.uil.unesco.org/system/files/the-youth-statement-on-learningcities_0.pdf

4. **Guidelines for Building Learning Cities (2015)** Холбоос:

<http://unesdoc.unesco.org/images/0023/002349/234987e.pdf>

Холбоо барих

ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисс
Нэгдсэн Үндэстний гудамж 14,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот



+976-70105652



natcom@unesco.mn



www.unesco.mn